

**СОР ХК-ИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ**

1. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Тус компани нь Монгол улсын хууль, Компанийн тухай хууль, НББ болон Татварын хууль, бусад хууль дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тус компанийн ТУЗ нь 2022 онд хоёр удаа хуралдаж хоёр асуудал хэлэлцэн тогтоол гаргасан болно.

Компанийн ТУЗ нь Сор ХК-ийн үйл ажиллагааг хэвийн явуулах, одоогийн нөхцөл боломжит зах зээлийг олох, Олон улсын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмж, техник технологийг нэвтрүүлэх, гадаад зах зээлд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэтийн зорилтыг тавин Гүйцэтгэх захиралд үүрэг болгон ажиллаж байна. Компанийн хувьд одоогийн байдлаар түрээсийн үйл ажиллагаа явуулж байгаа ба цаашдаа жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих Засгийн газрын бодлогын хүрээнд үйл ажиллагаа явуулахаар судалгаа хийж байна. Өнөөдрийн байдлаар "Ус суваг удирдах газар"-ын Урьдчилан цэвэрлэх байгууламж нь арьс ширний хашаанд байрлах үйлдвэрүүдийн бохирын ачаалаа дийлэхгүй байгаа нь манай байгууллагын хувьд баагүй асуудал болж байна. Арьс ширний хашаан дотор байрлах үйлдвэрүүд нь нийтийн эзэмшлийн талбай болон авто машины зам, явган хүний зорчих хэсэг гэх мэт газруудаар үйлдвэрийн технологийн бохир усаа шууд задгай асгаж байгаа нь ихээхэн сөргөөр нөлөөлж байна. Одоогийн байдлаар компанийн хүрээлэн буй орчны нөлөө хэт их бохирдолтой, эрсдэл өндөр байгаа тул компанийн үйл ажиллагаанд доривтой дэвшилт гаргах боломжгүй байна.

2. Удирдлагын талаарх мэдээлэл

Тус компани нь Гүйцэтгэх захирал, Ерөнхий няглан бодогч гэсэн бүтэц орон тоотой ажиллаж байна.

Гүйцэтгэх захирал Ц.Чулуунчимэг нь 1995 оны 02 дугаар сарын 03-нд Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл суманд төрсөн. 2003-2013 онд Тосонцэнгэл сумын 11-н жилийн дунд сургууль, 2014-2018 онд Улаанбаатар хот Их засаг олон улсын их сургууль Хууль зүйн сургуулийг Эрх зүйч мэргэжлээр бакалавр, 2019.11-12 сард АЕГ-н Архив, бичиг хэргийн ажилтнаар суралцсан. 2019.07-10 сар хүртэл Нотариатын туслах, 2020-2022.04 сар хүртэл БЗД, СБД, ЧД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд Шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар, 2022 оны 9 сараас Сор ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Ерөнхий няглан бодогч Ц.Цэцгээ нь 1960 онд төрсөн. 1978 онд 10 жилийн дунд сургууль, 1982 онд Аж-үйлдвэрийн няглан бодогч мэргэжлээр, 2002 онд онд няглан бодогч, эдийн засагч мэргэжлээр, 1998 онд Сингапур Улсад няглан бодох бүртгэл аудитын чиглэлээр тус тус суралцсан. 1978-1982 онд Ажилчны районы нэгдсэн эмнэлэгт няглан бодогч, 1982-2010 онд "Говь" ХК-д няглан бодогч, 2011 оноос "Блю скай кашемир" ХХК-д няглан бодогчоор ажиллаж байна.

3. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл

2022 онд 1422 м² талбай түрээслүүлж 71,107,213 төгрөгийн орлоготой ажилласан. Харин үйл ажиллагааны зардлын нийт дүн 119,288.897 төгрөг болсон ба 48,181,684 төгрөгийн алдагдалтай ажилласан.



"СОР" ХК-ИЙН 2022 ОНЫ ТАЙЛАН ТЭНЦЭЛ

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2020.12.31	2021.12.31	12/31/2022	Өөрчлөлт	
				<u>2021</u> 2020	<u>2022</u> 2021
Эргэлтийнхөрөнгө	7,527,594,780	7,480,668,909	118,010,807	1%	2%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,146,842.50	5,880,368.16	13,671,985.61	5%	-57%
Авлага	7,521,447,937	7,474,788,541	104,338,822	1%	1%
Барааматериал				#DIV/0!	#DIV/0!
Эргэлтийн бус хөрөнгө	947,236,862	917,387,777	887,538,693	3%	3%
Биетхөрөнгө	947,067,957	917,230,247	887,392,536	3%	3%
Биетбусхөрөнгө	168,904	157,531	146,157	7%	8%
НИЙТ ХӨРӨНГӨ	8,474,831,641	8,398,056,686	1,005,549,500.06	1%	735%
Богинохугацаатөртөлбөр (БХӨТ)	7,744,604,870	7,733,266,286	633,748,394	0%	1120%
Бэлтгэнийлүүлэгчидтөлөхөглөг	32,968,347	21,252,534	21,255,499	55%	0%
Банкныбогинохугацаатзээл				#DIV/0!	#DIV/0!
Бусад БХӨТ***	7,711,636,523	7,712,013,752	612,492,895	0%	8%
Уртхугацаатөртөлбөр (УХӨТ)	244,807,610	244,807,610		0%	#DIV/0!
Банкнызээл	244,807,610	244,807,610		0%	#DIV/0!
Эзэмшигчдийнөмч	485,419,162	419,982,790		16%	#DIV/0!
Өртөлбөрбазэзэмшигчийнөмчийнд үн	8,474,831,641	8,398,056,686	633,748,394	1%	1225%

"СОР" ХК-ИЙН 2021 ОНЫ ОРЛОГЫН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2020 он	2021 он	2022 он	Өөрчлөлт				
				<u>2021</u> 2020	<u>2022</u> 2021			
Борлуулалт								
Борлуулсанбүтээгдэхүүнийөртөг								
Бохирашиг								
Үйлажиллагаанызардал	80,205,538	68,633,524	70,650,163	17%	-3%			
Үйлажиллагааныбусорлого	73,519,536	63,257,030	71,107,213	16%	-11%			
Үйлажиллагааныбусзардал	51,272,025	60,059,878	48,638,734	-15%	23%			
Татварынөмнөхашиг	57,958,027.05	65,436,371.55	- 48,181,684.31					
Татвар								
Цэвэршиг	- 57,958,027.05	- 65,436,371.55	- 48,181,684.31					

төлөөлөн удирдах зөвлөл

4. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

ҮЦ ЭЗЭМШИГЧДИЙН НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД						
Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа 2023 оны 04-р сарын 07-ны өдрийн байдлаар хувьцааны тоо ширхэг 891,388, Хувьцаа эзэмшигчдийн тоо 1,641 байна.						
№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	тоо ширхэг	Эзлэх хувь	Брокер нэр	ДК-иудын	регистрийн дугаар
1	Блю скай кашемир ХХК	420,671	47.19	Гендекс		5209811
2	Титан инвест ХХК	151,000	16.94	Гендекс		2807386
3	Монгол даатгал ХХК	75,334	8.45	Бумбат Алтай ҮЦК ХХК		2117525

5. Ногдол ашгийн талаарх мэдээлэл

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02-р сарын 17-ны өдрийн Дугаар 23/01 тоот тогтоолоор "Cop" ХК нь 2022 оны байдлаар нийт 48,181,684 /дөчин найман нэг зуун наян нэгэн мянга зургаан наян дөрөв/ төгрөгийн алдагдалтай ажилласан ба ногдол ашиг хувиарлахад төлбөрийн чадваргүй байх тул 2022 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

6. Бусад шаардлагатай мэдээлэл

Компаний ТУЗ нь 9 гишүүнтэй.

Үүнд: ТУЗ-ийн даргаар **Б.Амарсанаа**

1. **Батжав овогтой Амарсанаа** 1987 онд Увс аймгийн Түргэн суманд төрсөн. Ам Бул 5. 1996-2006 онд Увс аймгийн Улаангом сумын Ю.Цэдэнбалын нэрэмжит ахлах 1-р сургууль, 2005-2009 онд МҮЭ-ийн холбооны дэргэдэх Хөдөлмөрийн дээд сургуулийн Увс дахь сургуульд "Бизнесийн удирдлага" мэргэжлээр бакалавр, 2013-2014 онд Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуулийн "Төрийн удирдлагын мэргшүүлэх" бакалавр, 2015-2016 онд Удирдлагын академид "Төрийн захиргааны менежментийн" магистр, 2019-2021 онд МУИС-ийн ХЗС-д "Эрх зүйч" мэргэжлээр бакалаврын боловсрол тус тус эзэмшсэн. 2008-2010 онд Увс- "Сайн Тус" ТББ-д Бизнесийн зөвлөх багш, төслийн менежер, 2012.01-2013.01 сар хүртэл "Бона Лекс" ХХК-д нягтлан бодогч, 2013.01 сараас 2015.02 сар хүртэл Хөдөлмөрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн газарт мэргэжилтэн, 2015.02 сараас 2016.07 сар хүртэл Аж үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар, мөн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх газарт тус тус мэргэжилтэн, "Сэтэрт групп" ХХК-д 2020 оны 12 сараас өнөөг хүртэл "Бизнесийн зөвлөх", 2019.02 сараас "Бизнес менежмент хөгжлийн академи" ТББ-ын Үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирлаар, 2022.02 сараас "Монциркон" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байна.

2. **Буурлууд овгийн Ишхүүгийн Дариймаа** 1964 оны 5-р сарын 12-ны өдөр Ховд аймагт төрсөн, 1972-1982 онд ерөнхий боловсролын сургууль, 1982-1986 онд МУИС-ийн Эдийн засгийн Факультетийг статистикч-эдийн засгийн ухааны бакалавр, 1996 онд мэргэшсэн нягтлан бодогчдын Институтыг нягтдан бодогч мэргэжлээр мэргэжил дээшлүүлсэн, 1998-1999 онд Техникийн их сургуулийн Бизнес удирдлагын магистр, 2000 онд Английн Лондон хотод Олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгө болгох сургалтанд хамрагдаж тус тус мэргэжил дээшлүүлсэн. 1986-1988 онд Ховд аймгийн АДХ-ийн гүйцэтгэх захиргаанд үйлдвэр, худалдаа хариуцсан мэргэжилтэн, 1988-2009 онд Говь ХК-нд мастер,

эдийн засагч, нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч, 2010-2017 онд Блю скай кашемир ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогч, 2017 оноос өнөөг хүртэл Блю скай кашемир ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

3. **Паномарева Светлана** 1975 оны 10 сарын 20-нд ОХУ-ын Курск хотод төрсөн, 1997 онд Курск хотын багшийн их сургуулийг гадаад хэлний багш мэргэжлээр төгссөн, Гадаад худалдааны зөвлөх.
4. **Хээхий Дарам Лизунова Таня** 1983 оны 02 дугаар сарын 19-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн. 1990-1993 Орос-Монголын хамтарсан 10 жилийн 3 дугаар дунд сургууль, 1993-2000 ОХУ-ын ЭСЯ-ны дэргэдэх 10 жилийн дунд сургууль Бурэн дунд боловсрол, 2000-2004 МУИС, ЭЗС-ийн Банк санхүүгийн анги. Бакалавр зэрэг, 2004-2006 ХБНГУ-ын Гамбург хотод Герман хэлнийн курс тус тус сурч төгссөн. 2006-2016 Чингис Хаан банканд Гадаад харилцааны ажилтан, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Судалгааны хэлтсийн захирал, ТУЗ-ийн ажлын албан, 2016 оноос өнөөдрийг хүртэл Монгол Даатгал ХХК ТУЗ-ийн даргын туслахаар ажиллаж байна.
5. **Цэндээс овогтой Чулуунчимэг** 1995 оны 02 дугаар сарын 03-нд Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл суманд төрсөн. 2003-2013 онд Тосонцэнгэл сумын 11-н жилийн дунд сургууль, 2014-2018 онд Улаанбаатар хот Их засаг олон улсын их сургууль Хууль зүйн сургуулийг Эрх зүйч мэргэжлээр бакалавр, 2019.11-12 сард АЕГ-н Архив, бичиг хэргийн ажилтнаар суралцсан. 2019.07-10 сар хүртэл Нотариатын туслах, 2020-2022.04 сар хүртэл БЗД, СБД, ЧД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд Шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар, 2022-06 сараас одоог хүртэл "Блю скай кашемир" ХХК-ийн Хуулийн зөвлөх-Хүний нөөцийн менежерээр ажиллаж байна.
6. **Гомбодорж овогтой Уянга** 1979 онд Бүгд Найрамдах Румын улс Брашов хотод төрсөн. Ам бүл 3. 2000 онд Сүхбаатар дүүргийн 10 жилийн 45-р дунд сургууль, 2004 онд Санхүү Мэдээлэл Зүйн "Хөхтэй хан" дээд сургуулийн Санхүүч мэргэжлээр, 2007 онд МУИС-ийн Эдийн Засгийн сургуулийг Бизнес удирдлагын магистраар тус тус төгссөн. 1998-2001 онд Бүгд Найрамдах Унгар улсын "Multi Textile" Сүлжмэлийн үйлдвэрт кетельчин, 2004-2012 онд Говь ХК-д Эдийн засагч, нягтлан бодогч, 2012 оноос одоог хүртэл Блю Скай кашемир ХХК-нд мониторингийн менежер, нягтлан бодогчоор ажиллаж байна.
7. **Даваа овогтой Нямхүү** 1966 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр Увс аймгийн Улаангом хотод төрсөн. Ам бүл 6. 1974-1984 онд Увс аймгийн 2-р арван жилийн дунд сургууль, 1984-1989 онд ОХУ, Хмельницкий хот, Технологийн дээд сургуульд "Технологич инженер" мэргэжлээр бакалавр, 2006-2008 онд ОХУ, Хмельницкий хот, Технологийн дээд сургуульд "Техникийн ухааны" магистрын зэрэг хамгаалсан. 1989-1991 онд Савхин гутлын үйлдвэрт Мастер, технологи инженер, 1991-1996 онд "Хан Хөхий" ББХК-д захирал, 1996-1998 онд "Арвижих" ХК, "Шинэст" ХК-ийн ТУЗ-ийн дарга, 1998-2004 онд "Монциркон" ХХК-ийн Ерөнхий захирал, 2004-2008 онд Нийслэлийн ИТХ-ийн төлөөлөгч, 2008-2012 онд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн-яамны Дэд сайд, 2012-2015 онд "Улаанбаатар БҮК" ХК-ийн ТУЗ-н гишүүн, 2015-2016 онд Аж үйлдвэрийн яамны Териин нарийн бичгийн дарга, 2016 оноос одоог хүртэл "Улаанбаатар БҮК" ХК-ийн ТУЗ-н даргаар, 2023 оны 3 сараас Блю Скай Кашемир ХХК-ийн ТУЗ-ийн даргаар тус тус ажиллаж байна.
8. **Огай Наталья Юрьевна** Эрхүү хотын Гадаад хэлний дээд сургуулийг 1993-1998 онд Хэл зүйч мэргэжилээр, Плехановын нэрэмжит Эдийн засгийн академийг Санхүүч мэргэжилээр тус тус төгссөн. 2003-2005 онд Сибэкология компанид Худалдааны хэлтсийн дарга, 2005-2016 онд Чинги хаан банканд Тусгай төслийн газар, 2016 оноос одоог хүртэл Монгол Даатгал ХК-ийн ТУЗ гишүүнээр ажиллаж байна.
9. **Өлзийдэлгэр овогтой Жамбалсүрэн** 1986 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр Завхан аймагт төрсөн. 1994-2004 онд Завхан аймгийн Улиастай хотын бүрэн дунд сургууль, 2004-2009 онд МУИС-ийн ХЭС-д Эрх зүйч мэргэжлээр бакалавр, 2018-

2020 онд СЭЗИС-д Бизнесийн удирдлагын магистр зэрэг хамгаалсан. 2012-2015 онд ЗГХЭГ-т Хуулийн шинжээч, 2015-2016 онд Аж үйлдвэрийн яаманд Ахлах мэргэжилтэн, 2016 оноос одоог хүртэл Скайтал ХХК-д Хүний нөөц, хууль эрх зүйн албаны захирлаар ажиллаж байна.

Компани нь өнөөдрийн байдлаар өөрийн үйл ажиллагааг явуулах боломжгүй байгаатай холбогдуулан өөрийн үйлдвэрийн байрны талбайг түрээслүүлэн ажиллаж байгаа ба түрээсийн ашгаар өөрийн зардлыг нөхөн ажиллаж байна.

Компанийн ТҮЗ нь цалин, урамшуулалгүй ажиллаж байна. Харин Гүйцэтгэх захирал 800,000 төгрөг, Ерөнхий нягтлан бодогч 500,000 төгрөгийн цалинтай ажиллаж байна.

Дээрх ТҮЗ болон гүйцэтгэх удирдлага болох эрх бүхий албан тушаалтан нь Компанийн хувьцаа эзэмшдэггүй болно.

Тайлангийн үнэн зөвийг баталгаажуулсан хүний нэр, гарын үсэг:

Сор ХК-ийн гүйцэтгэх захирал

Ц.Чулуунчимэг

Мэдээллийг бэлтгэж, хүргүүлсэн хүний нэр, гарын үсэг:

"Сор" ХК-ийн Нягтлан бодогч

Ц.Цэцгээ

